ТАТВАР, ОРЛОГЫН ГАЗРЫН ГУБ Р.ЭНХЗУЛИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хүрэх түвшин | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| НЭГ.“ ЗОРИЛТ 3: УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГЫГ ШУДАРГА, ҮР АШИГТАЙ, ҮР ДҮНТЭЙ БҮРДҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | Гаалийн болон бусад татвараас чөлөөлөх бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар | 100% | Гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдөн бүрмөсөн болон түр хугацаагаар орох гаалийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, зөвлөмж чиглэлээр хангаж ажилласан байна. | Тайлант хугацаанд татварын чөлөөлөлттэй холбоотойгоор батлагдсан хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх чиглэлийг тухай бүрт албан тоотоор газар, хороодод хүргүүлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br><br>2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 02-2/04 тоот албан бичгээр тухайн онд хэрэгжүүлэх татварын чөлөөлөлтийн хууль тогтоомжийн чиглэлийг гаалийн газар, хороодод хүргүүлсэн.<br><br>2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 180 дугаар тогтоолоор батлагдсан жагсаалтыг үндэслэн мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаанбуудайн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлөх чиглэлийг газар, хороодод 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 02-2/1720 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 2024.01.01-2024.12.10 | Биелэлтийн хувь: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Монгол Улсын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн дагуу Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж байгаа Булевиртид эмийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх чиглэлийг 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 02/2773 албан тоотоор гаалийн газар хороодод хүргүүлж ажилласан.<br><br>2024 онд Татварын чөлөөлөлттэй холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд 871 аж, ахуйн нэгж, 269 иргэний импортолсон нийт 658.32 сая ам.долларын бараанд ногдох 103.25 тэрбум төгрөгийн гаалийн татвар, 343.82 сая төгрөгийн онцгой албан татвар, 219.06 тэрбум төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг чөлөөлсөн байна. Үүнд:<br><br>-Гаалийн болон бусад татвараас чөлөөлөх хүсэлтийг edoc.ecustoms.mn цахим хуудсаар ирүүлсэн бичиг 482, хүсэлтийг шийдвэрлэж Гаалийн газар хороодруу явуулсан 276 албан бичиг.<br><br>-Гадаадын зээл, тусламжийн хүрээнд татвараас чөлөөлүүлэх тухай албан хүсэлтийг https://odamis.mof.gov.mn цахим хуудсаар нийт 1000 бүртгэлийн хуудас хүлээн авч цахим баталгаажуулан 192.7 сая USD бараанд ногдох 32,040.9 сая төгрөгийн гаалийн татвар, 343.8 төгрөгийн онцгой албан татвар, 68,517.0 сая төгрөгийн НӨАТ-ийн татварийг чөлөөлсөн байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Татвараас чөлөөлөгдөж бүрдүүлэлт хийсэн 7 мэдүүлэгт даатгалын зардлыг мэдүүлэг тус бүрт хуваан хийлгүй бүх зардлыг мэдүүлэг тус бүрт оруулж илүү дүнгээр татварын чөлөөлөлт эдлүүлсэн алдааг залруулж засварлуулсан.<br><br>Сангийн яамнаас ирүүлсэн 2024 оны 01 дүгээр сарын 29-ний 01/519 албан тоотын дагуу Эрчим хүчний яаманд хэрэгжиж буй “10 аймгийн төвийн дулааны станц барих” төслийн гүйцэтгэгч Бюксан инженеринг төлөөний газрын импортолсон техникийн шаардлага хангахгүй шугам хоолойн татвараас чөлөөлөгдсөн 30 гаалийн мэдүүлгийг хүчингүй болгож гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг төлүүлэх арга хэмжээг авч ажилллаж 2,7 сая ам.долларын бараанд ногдох 1.45 тэрбум төгрөгийн татварыг нөхөн төлүүлсэн. 2 албан тоот төлөвлөж тус компанид хүргүүлсэн. 5 удаагийн уулзалтыг зохион байгуулсан.<br><br>Тус газарт ирсэн 2022-2023 оны албан бичгийг үдэж хавтаслан архивд 31 боть хүлээлгэн өгсөн.<br><br>Иргэдийн хэрэглээний боловсролын төвийн шим тэжээл судлаач, Био анагаахын ШУ магистр, сансар марс төсөлийн хоол зүйч Э. Нэмүүзол “Эрүүл зөв хооллолт, амьдралын зөв дадал, зуршил, хамт олны дотоод уур амьсгал” сэдвээр Мэдээллийн цаг зохион байгуулсан. 2024.04.05<br><br>2024-04-09-ны өдрийн 02-2/1343 тоот албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд түр горимын хугацаа хэтэрсэн тоног | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төхөөрөмжийг зохих горимд байршуулах шаардлага хүргүүлсэн.<br><br>2024.04.01, 2024.04.23, 2024.06.14 2024.08.28-ны өдрүүдэд Сургалтын төвийн хүсэлтээр гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт нийт 7,5 цагийн сургалтыг Гаалийн татварын чөлөөлөлт сэдвээр явуулсан.<br><br>Чоногол ХХК, Мэтарго ХХК-иудаас ирүүлсэн гомдолд татвараас чөлөөлөх боломжгүй хариуг хүргүүлэн ажилласан. 2024-05-20 02-2/1996, 2024-05-28 02-2/2096, 2024.11.28 02-24938<br><br>Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд Чоногол трейд ХХК болон Мэтагро ХХК-ийн гомдлоор гаргасан нэхэмжлэлд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байна.<br><br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн татварын чөлөөлөлтийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар саналыг 2024.09.12-ны өдрийн 02/3668 тоот албан бичгээр саналаа хүргүүлсэн.<br><br>Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар нэвтрүүлэх горимын хүрээнд 28 албан тоотыг газар хороодод хүргүүлж хяналт тавьж ажилласан. Мөн гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар нэвтрүүлэн хугацаа хэтрүүлээд байсан Монгол газрын тос | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн 12 гаалийн мэдүүлгийн гарах бүрдүүлэлтийг хийлгэж 621,1 мянган долларын машин тоног төхөөрөмжийг буцаан гаргуулж горимын хэрэгжилтийг хангаж ажилласан.<br><br>Цахимаар хэрэгждэг Сангийн яамны бүртгэлийн хуудасны дагуу татвараас чөлөөлөх програмыг сайжруулж хандив тусламж зээлийн гаалийн бүрдүүлэлтийн мэдээг CAIS програмаас төсөл хөтөлбөрийн нэр, төсөл хэрэгжүүлэгч байгууллага, санхүүжүүлэгч зээл тусламж төрөл зэрэг мэдээг хүссэн хугацаагаараа гаргаж болдог болсон. 1 бүртгэлийн хуудсаар 1 бүрдүүлэлт хийдэг програмын сайжруулалтыг хийснээр мэдүүлэг гааль зөвшөөрөв төлөвт орсноор цахим бүртгэлийн хуудас нь чөлөөлөгдсөн төлөвт шилждэг болсон. | | |
| ЗОРИЛТ 4: ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭД БҮТЭЦ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ | | | | | | | |
| 2 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | Гаалийн байгууллагын бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | УИХ-ын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Улсын их хурлын 2023 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн "Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 107 дугаар тогтоолоор батлагдсан гаалийн албан татвараас хөнгөлөх хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай, үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийн жагсаалтад хамаарагдах барааг импортолсон 59 аж ахуйн | 2024.01.01-2024.12.10 | Биелэлтийн хувь: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэгжийн 2023 онд ногдуулсан гаалийн албан татвар болох 2.1 тэрбум төгрөгийн гаалийн албан татварыг буцаан олгох хүсэлтийг хүлээн авч, нягтлан шалгаж Сангийн Яамны төрийн сангийн газарт 3 удаагийн албан бичгээр хүргүүлэн ажилласан. | | |
| 3 | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 1. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулсан байна.<br>2. Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг ханган ажиллаж, тухай бүр холбогдох мэдээ тайланг дээд шатны байгууллагад хүргэсэн байна. | 1. Доорх мэдээ тайланг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Үүнд:<br><br>- Сангийн яаманд 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 02-2/276 тоот албан бичгээр 2023 оны төсвийн зарлагын мэдээг хүргүүлсэн.<br><br>-Гаалийн болон бусад татварын чөлөөлөлттэй холбоотой хуулийн хэрэгжилтийн биелэлтийг эхний хагас жилийн байдлаар нэгтгэн Сангийн яаманд хүргүүлэх ажлын дагуу ГЕГ-ийн Хуулийн хэлтэст 5 удаа тайлан хүргүүлсэн.<br><br>-Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн 01/1724 тоот албан бичгийн хүрээнд Засгийн газрын 107 дугаар тогтоолын биелэлтийг сүүлийн 2 жилийн байдлаар хүргүүлсэн.<br><br>-2024-04-15-17 өдрүүдэд УИХ-с зохион байгуулсан Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцлийг хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголд Гаалийн байгууллагын ажлын хэсэгт орж ажиллаж сонсголд оролцсон. Татварын чөлөөлөлтөөр | 2024.01.01-2024.12.10 | Биелэлтийн хувь: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | импортлогдсон сүүлийн 5 жилийн эмийн мэдээг гаргаж оролцсон.<br><br>Үндэсниий аудитын газраас 2024.11.11-ний өдрийн 08/2148 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу СОС хүүхдийн хотхоны 1998-2023 оны татварын чөлөөлөлтийн мэдээг 2024.11.15-ны өдрийн 02-2/4761 тоот албан тоотоор хүргүүлсэн<br><br>-"Ногоон автобусны" нээлттэй сонсголд оролцсон удирдлагуудад татвараас чөлөөлөгдөж орж ирсэн автобусны 2 жилийн мэдээг гаргаж өгсөн. 2024.05.19<br><br>“Гаалийн байгууллагын 2024 оны хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу улирал бүр тайланг ТЗУГ-т хүргүүлж ажиллсан.<br><br>Сангийн яамнаас хэрэгжүүлж буй “Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал” төслийн хүрээнд 2021-2022 оны импортолсон барааны татварын чөлөөлөлтийн мэдээг гаргаж хүргүүлсэн. | | |
| ***Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэх*** | | | | | | | |
| 1 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | Эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлж ажилласан байна. | 2023 онд төлсөн татварыг 2024 оны эхний улиралд буцаан олгохтой холбоотой Бүрдүүлэлтийн цахим төвд Засгийн газрын 107 дугаар тогтоолд хамаарахгүй барааг оруулсан эсэхийг нягтлан шалгаж алдааг засварлуулахаар 2024/12 дугаартай дотоод зурвасыг хүргүүлж ажилласан. | 2024.01.01-2024.12.10 | Биелэлтийн хувь: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2024 онд төлсөн татварыг 2024 оны эхний улиралд буцаан олгохтой холбоотой Бүрдүүлэлтийн цахим төвд Засгийн газрын 107 дугаар тогтоолийн дагуу хийгдсэн бүрдүүлэлтийг нягтлан шалгаж алдааг засварлуулахаар 2024.09.24-ний өдрийн 2024/123 тоот дотоод зурвасаар чиглэл хүргүүлсэн.<br>2023 онд Засгийн газрын 107 дугаар тогтоолийн дагуу 57 мэдүүлэгт засвар өөрчлөлт орсон тул уг тогтоолоор хийгдсэн гаалийн 551 мэдүүлэгт хяналт тавьсаны хүрээнд 17 алдааг илрүүлэн засварлуулсан.<br>Татварын чөлөөлөлтөөр хийгдсэн бүрдүүлэлтийн хамгийн их алдаа гардаг эрсдэл өндөртэй горимын код, хэлцлийн код, чөлөөлөлтийн кодыг 401, 402, 403 горимын хүрээнд нягтлан шалгаж 72 алдааг илрүүлж мэдүүлгийг засварлуулж ажилласан.<br>Эрчим хүчний яаманд хэрэгжиж буй “10 аймгийн төвийн дулааны станц барих” төслийн гүйцэтгэгч Бюксан инженеринг төлөөний газрын хууль сахилтын түвшин эрсдэлтэй гэж мэдээлэл ирсэн тул БДШГ-т 2024/126 тоот дотоод зурвасаар бүрдүүлэлтийн дараах шалгалт оруулах хүсэлт хүргүүлсэн бөгөөд шалгалтаар гаалийн хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдсон бөгөөд шалгалтын ажиллагаа үргэлжилж байна.<br><br>Сангийн яамнаас ирүүлсэн 2024 оны 01 дүгээр сарын 29-ний 01/519 албан тоотын дагуу “10 аймгийн төвийн дулааны станц барих” төслийн гүйцэтгэгч Бюксан инженеринг төлөөний газрын импортолсон техникийн шаардлага хангахгүй шугам хоолойн татвараас чөлөөлөгдсөн гаалийн мэдүүлгийг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүчингүй болгож гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг төлүүлэх арга хэмжээг авч ажилллаж 2,7 сая ам.долларын бараанд ногдох 1.45 тэрбум төгрөгийн татварыг нөхөн төлүүлсэн. 2 албан тоот төлөвлөж тус компанид хүргүүлсэн. 5 удаагийн уулзалтыг зохион байгуулсан. | | |
| 4 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | ГЕГ-ын удирдлага, Захиргааны зөвлөл, Мэргэжлийн зөвлөл, Шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд биелүүлж ажилласан байна. | 1. Удирдлагын шуурхай хуралдаан, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Захиргааны зөвлөлийн хуралдаан, Онлайн хурлаас ТОГ-т өгсөн нийт 5 үүрэг даалгавар, 2 зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллахад оролцов.<br>2. Сангийн яамны АУДИТ-д татварын чөлөөлөлтийн мэдээг сүүлийн 2 жилээр гаргаж танилцуулсан.<br>3. Дэд даргаас өгөгдсөн үүргийн хүрээнд Хорио цээрийн хэлтэст Засгийн газрын 2021 оны 05-р сарын 12-ны өдрийн 143 дугаар тогтоол, 2023 оны 03 дугаар сарын 22-ний өдрийн 107 дугаар тогтоол, 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 180 дугаар тогтоолын биелэлтийн тайланг 6 удаа гаргаж хүргүүлсэн. | 2024.01.01-2024.12.10 | Биелэлтийн хувь: 100% |
| 5 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | Ажлын цаг ашиглалтын 2023 оны үнэлгээг өмнөх оны эхний хагас жилийнхээс бууруулахгүй ажиллана. | 2024 онд ажиллавал зохих 236 өдөр, 1888 цаг ажиллахаас 236 өдөр, 1888 цаг ажилласан байна. Өвчтэй,чөлөөтэй болон тасалсан цаг байхгүй. | 2024.01.01-2024.12.10 | Биелэлтийн хувь: 100% |
| 6 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | Гадаад орны Засгийн газар, банк санхүүгийн | - Сургалтын төвийн хүсэлтээр 160 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт ХҮМҮҮНЛЭГИЙН БОЛОН БУЦАЛТГҮЙ | 2024.01.01-2024.12.10 | Биелэлтийн хувь: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгууллагаас олгосон зээлийн хүрээнд нийлүүлсэн бараа, буцалтгүй тусламжийн хүрээнд татвараас чөлөөлүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй аж ахуйн нэгж байгууллагуудад зориулсан сургалт зохион байгуулсан байна. | ТУСЛАМЖ, ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛЭЭР АВСАН БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ГААЛИЙН БОЛОН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ сэдвээр 7.30 цагийн сургалт явуулсан. 2024.04.01, 2024.04.23, 2024.06.14 2024.08.28-ны өдөр<br><br>"Гаалийн байгууллагын 2024 оны хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний дагуу улирал бүр тайланг ТЗУГ-т хүргүүлж ажилласан. | | |
| **Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ** | | | | | | | |
| | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор | 100% | Сургалтад хамрагдсан байна. | Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 аргазүйн цахим сургалтад 4 удаа хамрагдсан.<br>Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан УИХ-ын сонгуулийн тухай хууль тогтоомжийг төрийн албан хаагч зөрчихөөс урьдчилан сэргийлэх нь сэдэвт цахим сургалтанд хамрагдсан.<br>2024-06-16-2024-06-24 ний хооронд БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах оронд<br>Монгол Улсын улаан загалмай нийгэмлэг, БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны (ӨМӨЗО) Улаан загалмай байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан "Анхны тусламжийн сургагч багш бэлтгэх сургалт"-д ХБГ-ын ГУБ Лхагвачулууны хамт оролцсон. | 2024.01.01-2024.12.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, | 100% | Хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн, өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна. | Гаалийн захиргаа, дотоод ажлын систем /CERP/-д байршуулсан БСҮХ-ны 2023 оны А/8 дугаар тогтоолоор батлагдсан "Хилийн боомтод мөрдөх нийтлэг журам", ГЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журамт өөрчлөлт оруулах тухай, Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх, нөөцийн санг ашиглах журам, Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам, Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах журам, Төрийн албаны шалгалт өгөх болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам, Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тушаалын төсөл болон ЗБН-үүдээс байршуулсан сургалтанд хамрагдсан тайлан, сэрэмжлүүлэг, заавартай танилцсан. | 2024.01.01-2024.12.10 | 100% |

ТАЙЛАНГИЙН БИЕЛЭЛТ ОРУУЛСАН:

ТАТВАР, ОРЛОГЫН ГАЗРЫН ГУБ .................................. / Р.ЭНХЗУЛ/

Огноо: 2024.12.10

1050

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ

РАДНААСЭДЫН ЭНХЗУЛ

2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Нэгжийн нэр: ТАТВАР, ОРЛОГЫН ГАЗАР

## 1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| Зорилт 1. ЗОРИЛТ 3: УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГЫГ ШУДАРГА, ҮР АШИГТАЙ, ҮР ДҮНТЭЙ БҮРДҮҮЛЭХ-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт | | | | | |
| 1. | Гаалийн болон бусад татвараас чөлөөлөх бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт | 60 | 10 | 70 | |
| 2. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 60 | 10 | 70 | |
| 3. | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт / Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг ханган ажиллаж, тухай бүр холбогдох мэдээ тайланг дээд шатны байгууллагад хүргэсэн байна. Хуулийн төсөлд санал өгөх/ | 60 | 10 | 70 | |
| ***Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэх*** | | | | | |
| 1. | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | 55 | 8 | 63 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2. | Үүрэг даалгаврын биелэлт | 60 | 10 | 70 | |
| 3. | Ажлын цаг ашиглалт | 60 | 10 | 70 | |
| 4. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Татварын чөлөөлөлтийн сургалтыг харилцагч нарт зохион байгуулах/ | 60 | 10 | 70 | |
| **Дундаж оноо:** | | | | **69** | |

| **Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ** | | | | |
|---|---|---|---|---|
| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийг хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | 86.6 | 13 | |
| 2 | Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | 86.6 | 13 | |
| **Дундаж оноо:** | | | **13** | |

## 3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 3. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 4. | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6 | Мэргэжлийн ур чадвар 1. | 7 | |
| **Дундаж оноо:** | | **7** | |

## 4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8) |
|---|---|---|

| | 1 | 2 |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 7 |
| 2. | Багаар ажиллах | 7 |
| 3. | Харилцаа | 7 |
| | **Дундаж оноо:** | **7** |

**5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | 69 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 13 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | 7 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 7 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | **96.00** |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

Татвар, орлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ............................... /С.Баярмаа/

2024..........

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Гаалийн улсын байцаагч ............................... /Р.Энхзул/

2024..........

***Үнэлгээг хянасан :***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

Дэд даргын албан үүргийг түр

орлон гүйцэтгэгч ............................... /Г.Энхтайван/

XII/20, 2024

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

Хүний нөөцийн хэлтсийн ГУАБ ............................... /Ө.Тэгшээ/

2024.12.20

***Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч***

Дарга ............................... /Р.Отгонжаргал/